

## УДИРТГАЛ ҮГ

Бид та бүхэнд манай хүрээлэнгээс эрхилэн хэвлүүлдэг “Acta Mongolica” сэтгүүлийнхээ 2012 оны ээлжит дугаарыг өргөн барьж байна. Өнгөрч байгаа 2012 онд бид шинэ тутам өргөжин тэлж байгаа Монгол судлалын хүрээлэнгийнхээ (МСХ) үйл ажиллагааг идэвхижүүлэх чиглэлээр дотоод гадаадад хэд хэдэн төрлийн тодорхой ажил санаачлан төлөвлөж, зохион байгууллаа.

Үүний нэг нь Монгол Судлалын Үндэсний Зөвлөл, ОУМСХолбооноос санхүүжүүлэн тусалж дэмжсэн “МОНГОЛ СУДЛАЛЫН ШИНЭ ЧИГ ХАНДЛАГА” олон улсын эрдэм шинжилгээний бага хурал юм. Энэ хуралд Монгол, Австрали, БНХАУ, ОХУ, Их Британи, Япон, БНСУ, ХБНГУ, Унгар зэрэг орны 40 орчим монголч эрдэмтэн, үе үеийн судлаачид оролцож Монголын түүх, соёл, нийгэм, хэлшинжлэл, эх бичиг, утга зохиолын чиглэлээр илтгэл хэлэлцүүлсэн билээ. Хурлын нэгэн онцлог бол үе үеийн судлаачид тэр дундаа залуу монгол судлаачид олноор оролцсон явдал бөгөөд олон улсын монголч эрдэмтэд маань өөрсдийн хамгийн сүүлийн үеийн судалгааны шинэхэн үр дүнгээ хэлэлцүүлэхээр хүрэлцэн ирсэн явдал юм.

Хурлыг нээж МУИС-ийн Захирал, МСХ-гийн Ерөнхийлөгч профессор С.Төмөр-Очир МУИС-ийн монгол судлалын өнөөгийн байдал, зорилго чиглэлийн талаар үг хэлж, дотоод гадаадын монголч эрдэмтэдийг бүх талаар дэмжиж ажиллахаа мэдэгдлээ.

Манай зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд Монгол Улсын эрдэмтэн профессор, доктор С. Дулам, Ш. Чоймаа, Э. Лувсанбалдан, Л. Маналжав, Э. Равдан, З. Багжаргал, Д. Энхцэцэг, Р. Дарьхүү, Л. Чулуунбаатар, С. Урантөгс, Ж. Долгорсүрэн, Я. Ганбаатар, С. Багтулга, До. Цэнджав, Г. Галбаяр, Х. Сүглэгмаа, Б. Мөнхбаяр, С. Батхишиг, залуу судлаач Д. Төгөлдөр, Б. Баяртуул, Б. Оюунцэцэг, Г. Ганзул, Ц. Онон, Ц. Отгонсүрэн, Б. Пүрэвсүрэн, Ц. Цогзолмаа, М. Энхжаргал, Д. Энхжаргал, Т. Эрдэнэ-Очир, Р. Бигэрмаа, Тоёо Мизүтани, Б. Аюуш, Австралийн Үндэсний Их Сургуулийн Монгол судлалын төвийн захирал, профессор Ли. Нарангоо, БНХАУ-ын эрдэмтэн Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн секторын эрхлэгч д-р Цэнгэл, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын д-р Б. Р. Зориктуев, ХБНГУ-ын Гёттингэний Их Сургуулийн эрдэмтэн, д-р Рекэл Жоханес, Японы эрдэмтэн Токиогийн Гадаад Судлалын Их Сургуулийн профессор Х. Фүтаки, К. Окада, Акитагийн Их Сургуулийн багш, дэд профессор Ганбагана, БНСУ-ын эрдэмтэн профессор Хонг-Жин Ким, Хангүүгийн Гадаад судлалын их сургуулийн профессор Д. Отгонцэцэг нар хүрэлцэн ирж илтгэл тавьсан бол Английн монгол судлаач Алан Сандерс, ХБНГУ-ын монгол судлаач профессор Удо Баркман нар эчнээ илтгэл тус тус хэлэлцүүлсэн нь монгол судлалын шинэ чиг хандлагыг тодорхойлоход зохих үр дүнгээ өглөө.

Ингээд та бүхэнд энэ удаагийн сэтгүүлийн дугаараас тус хуралд илтгэл хэлэлцүүлсэн эрдэмтэдийн бүтээлийг эрдэм шинжилгээний өгүүллийн хэлбэрээр уншиж судлах боломж гарч байгаад бид баяртай байна. Та бүхэн манай сэтгүүлийн талаар санал бодлоо [ims\\_pum@pum.edu.mn](mailto:ims_pum@pum.edu.mn) хаягаар ирүүлнэ үү.

Эрдэм номын үйлс дэлгэрэх болтугай.

СЭТГҮҮЛИЙН ЭРХЛЭГЧ ДОКТОР, ПРОФЕССОР ЖАНЦАНГИЙН БАТ-ИРЭЭДҮЙ

Улаанбаатар хот, 2012 оны 12 дугаар сарын 12



"MONGOLIAN STUDIES - NEW APPROACHES" International Conference on Mongolian Studies  
The Institute for Mongolian Studies, NUM